

## ХАН УЛСЫН ҮЕИЙН ХЯТАДЫН ФИЛОСОФИЙН ОНЦЛОГ

Р.ДАРЬХҮҮ

МУИС, НШУС, Философийн тэнхим

**Түлхүүр үг:** Дун Жун Шу, "У-Чан", "Гурван - Ган", Юань Ци, Ван Чун

**Товч утга:** Хан улсын үеийн философи нь Хятадын философийн түүхэнд онцгой байр суурь эзэлдэг болохыг энэхүү өгүүлэлд авч үзнэ.

Хятадын түүхэнд Хан улсын үе (МЭӨII-МЭII зуун) нь томоохон байр суурь эзэлдэг. Түүхийн сурвалжид өгүүлсэнээр Хан улсын үед ялангуяа У-ди хааны үед улс орон их хөгжиж, ард олон хөрөнгөжиж, газар нутгийн хэмжээ нь Ромоос ч давж, улс орон нь хүчирхэг болжээ. Агуулахууд үр тариандаа хахаж, санхүү нь үнэт эдлэлээр дүүрэн, бөс даавуу, торго ихээр үйлдвэрлэж, төмрөөр газар тариалангийн багаж зэвсэг хийн, үйлдвэрлэл ихээхэн өсөн нэмэгдэж байжээ. Мөн энэ үед Хятадад өрнө дорнын харилцааны суурь тавигдсан гэж үздэг. Тэр үед төрийн сургууль нээж, эл сургуулиар төрийн түшмэдийг бэлтгэж, төрийн албыг бэхжүүлэхэд чиглэсэн бодлого явуулсан байна. Энэ үед соёлын талаар их олон амжилт гарчээ. Тэр үеийн төрийн албан ёсны философи нь Күнзийн философи байв. Бүх шатны сургуульд "таван ном"-ыг судалж, "таван номын багшийг" тодруулж өргөмжлөл өгдөг, төрийн албанд хүмүүсийг авч ажиллуулахдаа Күнзийн үзэл сургаалаар шалгалт авч, сонголт хийдэг шалгалтын тогтолцоо бий болжээ. У-ди хаан нь эрдэмтдийг төрийн ордондоо урьж, улс орны томоохон асуудлыг шүүн хэлэлцэхэд тэдний саналыг чухалчилдаг байсан гэдэг. Тийм томоохон эрдэмтдийн нэг нь "Хан улсын Күнз" хэмээн алдаршсан Дун Жун Шу юм. Мөн тэр үед маш хүчтэй байсан Күнзийн сургаалыг шүүмжилсэн материалист Ван Чун нь эртний натурфилософийг сэргээн шинэчилсэн буй.

Хан улсын үед шинжлэх ухаан ч урагшлан хөгжсөн түүхтэй. Математик, анагаах ухаан, одон орон, цаглабар зохиох үйл хэрэгт ихээхэн ахиц дэвшил гарсан буй. Оныг эхний сараас тоолдог цаглабар зохиож, газар хөдлөлийг хэмжих багаж бүтээж, мэс заслын багаж бүтээж, мэс засал хийдэг болжээ. Түүнчлэн алдарт түүхч Сыма Цянь "Түүхэн тэмдэглэл" зохиолоо бичиж, Хятадын түүх бичлэгийн эхлэлийг тавьсан болно.

Энэ үеийн өөр нэг онцлог нь Хятадад буддын шашин анх дэлгэрсэн явдал мөн. Төрийн зүгээс буддизмыг дэмжиж, судар номыг нь орчуулж

эхэлсэн буй. Мөн даогийн шашин ч хүчтэй болж, "шар алчууртны" бослогын гол суртал болж байсан түүхтэй.

Хан улсын үеийн Хятадын философийн онцлогийг Дун Жун Шу, Ван Чун нарын философиос тодорхой харж болно. Хан улсын үеийн нэрт философич, нийгмийн зүтгэлтэн Дун Жун Шу<sup>1</sup> (МЭӨ179-104) нь Хан улсын Гуаньчуан муж буюу одоогийн Хэбэй мужид язгууртны гэр бүлд төрсөн байна. Тэрээр бага наснаасаа эрдэмд шамдан суралцаж, Күнзийн сургаалыг баримтлан улмаар төрийн албан ёсны философи болоход чухал үүрэг гүйцэтгэсэн хүн юм. Дун Жун Шу нь хааны шадар зөвлөхийн алба хашиж байжээ. Мөн түүнчлэн Дун Жун Шу нь төрийн албаны шалгалтын тогтолцоог бий болгоход голлох үүрэг гүйцэтгэжээ. Энэхүү тогтолцоогоор төрийн албанд ороход өмч хөрөнгө, угсаа гарал бус, харин улс даяар төрөөс нэгэн зэрэг, тогтмол явуулдаг шалгалтын дүн асуудлыг шийддэг байв.

Дун Жун Шу нь Күнз, Мэнз, Сюнь-зийн философийг сайтар судалж, эмхлэн цэгцлэхийн хамт натурфилософийг бас судалж, тэдгээрийг хослуулан өөрийн философийг боловсруулжээ. Тэрээр олон жил төрийн албанд ажиллаж байгаад амьдралынхаа сүүлийн жилүүдэд ордноос явж, ном бүтээл туурвих болжээ. Дун Жун Шу нийтдээ 82 зохиол бичсэн гэх бөгөөд гол бүтээлүүд нь "Хан Шу" (Хан улсын түүх), "Чунь-цю фань лу" (Хавар намрын элбэг шүүдэр), "Чжоуи" зэрэг болно. Дун Жун Шу-гийн философид хүний болон нийгмийн амьдрал нь тэнгэрийн хуулиар тогтоогдсон байдаг хэмээх космологийн онол, ертөнц дахь бүх юмс харилцан нягт холбоотой тухай сургаал, хүний уг чанарын баримтлал, нийгмийн ёс зүй, нийгмийн философи, түүхийн философи, улс төрийн философийн асуудал голлох байр суурь эзэлдэг.

Дун Жун Шу-гийн философийн гол зорилго нь нийгэм болон хүний амьдрал үйл ажиллагааг зохицуулах түгээмэл зарчмуудыг боловсруулах явдал байжээ. Түүний философийн үзэл санааны гол эх сурвалж нь Күнз, Мэнз, Сюнь-зийн философи, мөн Зоу Яны натурфилософийн "У-син", инь, яны сургаал юм. Тэрээр түүнчлэн даосизм, моизмд ч шүүмжлэлтэй хандаж байв.

Онтологи үзлийн хувьд Дун Жун Шу нь үүн ба тэнгэрийн харилцан нөлөөллийн асуудлыг натурфилософи, даосизм, күнзийн сургаал дээр түшиглэн судалж, өөрийнхөөрөө тайлбарласан юм. Түүний үзлээр, тэнгэр (тянь) бол бүхний дээр оршигч дээд эхлэл, тэнгэр үгүй бол нэг ч юм

<sup>1</sup> История Китайской философии. М., 1989, с. 189

оршихгүй. "Тэнгэрийн хүсэл зоригийг харахад бэрх, тэнгэрийн үзлийг олоход бэрх" хэмээн сургажээ. Тэнгэр хэмээх ойлголт нь Хятадын философийн нэг үндсэн ойлголт байдаг билээ. Энэхүү ойлголтыг эртний Хятадын философид хоёр үндсэн утгаар хэрэглэсэн буй. Нэг талаас, байгаль гэсэн утгаар, нөгөө талаас бүхнийг бүтээсэн, захирч байдаг агуу хүч (бурхан) гэсэн утгаар хэрэглэдэг. Дун Жун Шу-гийн хувьд натурфилософийн тэнгэр бол байгаль гэсэн ойлголт, Күнзийн сургаал дахь тэнгэрийн хүсэл зориг хэмээх ойлголтуудыг нэгтгэн хослуулан авч хэрэглэсэн онцлогтой, өөрөөр хэлбэл, дээрх хоёр утгыг нэгтгэн үзжээ. "Ертөнц нь тэнгэр ба газар, инь ба ян, гал, ус, мод, шороо, төмөр хэмээх таван махбодь, хүн зэрэг үндсэн элементүүдээс бүрддэг"<sup>1</sup> хэмээн өөрийн космологийн онолдоо Дун Жун Шу тайлбарласан буй. Тэрээр таван махбод (У-син) нь модноос эхлээд гал, шороо, төмөр, ус, мод гэсэн дарааллаар үүсч, харилцан бие биедээ шууд нөлөөлдөг, бас харилцан нягт холбоотой, нэгдмэл мөн чанартай гэж үздэг. Энэхүү үзэл нь ертөнц нэгдмэл мөн чанартай болохыг авч үзсэн хэрэг мөн. Түүнчлэн Дун Жун Шугийн философид "Инь, яны харилцан үйлчлэл нь ертөнцийн хувьсал, өөрчлөлтийн үндэс болдог" хэмээх натурфилософийн үзлийг шууд уламжлан авсан байдаг. Инь ба ян хоёр нь нэмэгдэж, бас хорогдож байдаг. Тухайлбал, Ян хүч нэмэгдэхэд хавар ирнэ, ян хүч дээд цэгтээ хүрэхэд зун болно. Яны хүч дээд цэгтээ хүрээд, буурч эхлэхэд Инь хүч нэмэгдэж эхэлнэ. Тэгэхэд намар болж, инь хүч дээд цэгтээ хүрэхэд өвөл болно. Ийнхүү дөрвөн улирал солигдох нь байгалийн жам ёс бөгөөд инь, ян хүч нэмэгдэх, хорогдохын үр дагавар хэмээн үздэг.

Цааш нь, Дун Жун Шу үзэхдээ: "Хүн, тэнгэр, газар гурав нь "бүх юмны үндэс мөн", тэнгэр тэдгээрийг төрүүлнэ, газар тэдгээрийг үржүүлнэ, хүн тэдгээрийг төгөлдөржүүлнэ" хэмээн энэ гурав нь харилцан нягт холбоотой болохыг онцолжээ. Мөн тэрээр "тэнгэрт баярлах, уурлах зан байдаг, мөн гуниг баяслыг мэдрэх сэтгэл байдаг нь хүн шиг юм. Хэрэв тийм бол тэнгэр ба хүн хоёр нь нэг юм."<sup>2</sup> хэмээн бичсэн буй. Энэ бол хүн ба тэнгэр нь нэгэн төрлийн үзэгдэл хэмээн үзсэн хэрэг мөн. Ийнхүү түүний үзлээр тэнгэр бол хүний эх дүр, хүн бол тэнгэрийн хуулбар ажээ.

Мөн түүний үзлээр "хүн уг чанараараа хоёрдмол шинжтэй. Хүнд син буюу хүнлэг чанар, сайн үйлийн эхлэл, цин буюу шунал, муу үйлийн эхлэл байдаг. Син нь тэнгэрийн ян-тай адил, цин нь тэнгэрийн инь-тэй адил" байдаг ажээ.

<sup>1</sup> Чунь-цю фань лу – Древнекитайская философия. Эпоха Хань. М., 1990

<sup>2</sup> Фэн Ю Лань. Хятадын философийн товч түүх. УБ., 2003 172 дахь тал

Иинхүү Дун Жун Шу нь хүний уг чанарын талаар Мэнз ба Сюнь-зийн эсрэг үзлүүдийг нэгтгэж, хүн уг чанараараа сайн ба муу талуудын аль алиныг нь агуулдаг хоёрдмол шинжтэй хэмээн үзжээ.

Нийгмийн шинэ ёс зүйг боловсруулах нь түүний философийн нэг зорилго байсан гэж үзэж болно. Тэрээр нийгэмд дээдэс, доодос, эрэгтэй, эмэгтэй, эцэг хүү зэрэг нийгмийн ялгарал зайлшгүй байдаг учир тэрхүү эсрэг харилцааг зохицуулагч байх ёстой. Тийм гол зохицуулагч нь ёс зүй гэж үзээд, эзэн харъяатын, эцэг хүүгийн, эр эмийн харилцаа зэрэг эсрэг харилцаа нь инь, яны зарчимд үндэслэнэ хэмээн тайлбарлажээ. Тухайлбал, эзэн-ян, харъяат-инь, эцэг-ян, хүү-инь, эр-ян, эм-инь юм.

Күнзийн сургаалд хүмүүсийн харилцааны таван хэв маяг байдаг. Үүнд: эзэн харъяатын, эцэг хүүгийн, эр эмийн, ах дүүгийн, найз нөхдийн харилцаа болно. Харин Дун Жун Шу нь эдгээр харилцаанаас гурвыг онцолж, "гурван ган" гэдэг нэр томъёог авч үзжээ. "Ган" гэдэг сйлголт нь торны бүх утсыг холбодог гол утас юм. Тэгэхлээр нийгмийн гол харилцаа нь эзэн харъяатын, эцэг хүүгийн, эр эмийн харилцаа хэмээн тэрээр онцолжээ. Цааш нь тэрээр нийгмийн эдгээр гол харилцааг зохицуулагч "У-чан" буюу ёс суртахууны таван дээд зарчмыг Күнзээс уламжлан хөгжүүлжээ. Үүнд: хүнлэг ёс, шударга ёс, ухаалаг мэргэн байх, ёс журмыг дээдлэх, үнэнч байх эдгээр болно. Энэхүү таван зарчим нь таван махбодид үндэслэдэг. Хүнлэг ёс нь мод, шударга ёс нь төмөр, ухаалаг байдал нь ус, ёс журмыг дээдлэх нь гал, үнэнч чанар нь газар махбодид тус тус үндэслэдэг ажээ.

Эндээс үзвэл, Дун Жун Шу-гийн хувьд хүн болон нийгмийн амьдралын үндэс, гол зохицуулагч нь ёс зүй юм. Үнэхээр ёс зүйгээс ангид хүний болон нийгмийн амьдрал хэвийн оршин тогтнох боломжгүй билээ.

Дун Жун Шу-гийн нийгэм-улс төр, түүхийг үзэх үзэл нь өөрийн онцлогтой. Түүний үзлээр, "нийгэм бол байнга өөрчлөгдөж, шинэчлэгдэж байдаг. Улс гүрэн бүхэн өөр өөрийн үүсэл, хөгжил, мандал, мөхөлтэй, өөрийн өвөрмөц онцлогтой. Тэнгэр ба дао бол улс гүрний нийгэм түүхийн оршин тогтох үндэс болдог. Хэдийчинээ тэнгэр ба даог хүндэтгэнэ, төдийчинээ удаан оршин тогтдог"<sup>1</sup> гэжээ.

Түүнчлэн нийгмийн хөгжил нь улиран давтагдах шинжтэй гээд, таван махбод өөр өөрийг төрүүлдэгтэй адилтган үзжээ. Тухайлбал, Юй улс нь газар, Ся улс нь мод, Шан улс нь төмөр, Жоу улс нь гал, Цин улс нь ус гэх мэтээр бие биеийгээ дийлж, ээлж дараалан солигдож байдаг жамтай ажээ.

<sup>1</sup> Чунь-цю фань-лу – Древнекитайская философия Эпоха Хань. М., 1990

Тэрээр "хаан бол улс орныг авч явдаг. Хаан бол улс орны эцэг. Хааны зарлиг бол тэнгэрийн хүсэл зориг" хэмээх Күнзийн улс төрийн үзлийг шууд уламжлан авчээ. Түүний үзлээр, "Тэнгэр нь хүнийг сайны "үндэс" бүхий уг чанарын боловч, хүмүүс өөрсдөө сайн болж чадахгүйгээр бүтээсэн юм. Тэгэхлээр, тэднийг сайн болгох төрийн эзнийг дээр нь тавьжээ. Тэнгэрийн таалал ийм буюу". Төрийн эзэн нь сайн үйл, шагнал, шийтгэл, хууль цаазыг тулгуурлан төрийн хэргийг явуулна. Энэхүү "удирдлагын дөрвөн зарчмыг" дөрвөн улиралтай холбон тайлбарлахдаа "Тэнгэрт дөрвөн улирал бий, төрийн эзэнд захирах дөрвөн зам бий" гэжээ. Цааш нь, тэрээр, түшмэдийг дөрвөн зэрэгт хувааж, түшмэлд гурван туслагч байдаг нь нэг улирлын гурван сар мэт байдаг. Ийнхүү тэнгэр (байгали) ба хүн (нийгэм) харилцан ойр холбоотойг онцолжээ. Төр нь удирдлагын ёсноос гажвал, тэнгэрийн дургүйцлийг төрүүлж, газар хөдөлж, ган үер зэрэг тэнгэрийн гэсгээлийг үздэг хэмээн тайлбарласан байдаг.

Ийнхүү Дун Жун Шу нь Хятадын сонгсдог философийн үзлүүдийг нэгтгэж дараа дараагийн үеийн философийн хөгжилд хүчтэй нөлөөлсөн юм. Энэ талаар Өрнийн судлаач Рассел Керкланд бичихдээ: "Дун Жун Шу нь Хятадын философийн түүхэнд өөрийн гүнзгий ул мөрийг үлдээсэн философичдын нэг мөн"<sup>1</sup> гэжээ. Түүний философийн гол баримтлал нь ертөнц дэх бүх юмс харилцан нягт холбоотой хэмээх нэгдлийн зарчим мөн.

Хан улсын үеийн өөр нэг нэрт соён гэгээрүүлэгч, шүүмжлэгч, натуралист, шашингүйн үзэлтэн Ван Чуны үзэл сургаалыг авч үзье. Ван Чун (27-97) нь бие даан бичиг үсэгт боловсорч, Хан улсын нийслэл Лоян хотод багахан түшмэлийн алба хааж байгаад, удалгүй орхиж судалгаа хийж, ном бүтээл олныг туурвижээ. Тэрээр өөрөөсөө өмнөх үеийн натурфилософи, даосизм, Күнзийн сургаал, моизм, легизмийг бүгдийг судалж, тэр бүхнээс суралцахын хамт өөрийн философийн үзлийг дэвшүүлсэн байна. түүний философийн гол бүтээл нь "Лунь Хэн"<sup>2</sup> (Шүүмжлэлт эргэцүүлэл) юм. Энэхүү бүтээлдээ Ван Чун тухайн үед маш хүчтэй тархсан Дун Жун Шу-гийн философийг шүүмжлэлтэйгээр авч үзэж, өөрийн үзэл онолоо илэрхийлжээ. Дун Жун Шу-гийн философид Күнзийг бурханчлан шүтэх болсонд шүүмжлэлтэй хандаж, Күнзийн үзэл сургаалд өөрийн үнэлэлтийг өгчээ. Тэрээр Күнз нь аугаа сэтгэгч гэдгийг хүлээн зөвшөөрсөн бөгөөд харин түүнийг бурханчлан шүтэхийг эсэргүүцжээ.

<sup>1</sup> Великие мыслители Востока. Перевод с англ. М., 1994 с.87

<sup>2</sup> Lun- heng. Transl. by A. Forke. V. 1-2. N.V. 1962

**Байгалийг үзэх материалист үзэл.** Ван Чун хэлэхдээ: "Байгалийн бүх юмс өөрөө төрж бий болдог. Тэнгэр бол байгалийн үзэгдэл, ертөнцийн бүх юмс нь "Юань-ци" хэмээх анхдагч эхлэлтэй хэмээн бүх юмс нь ци-гийн нягтралаас үүсдэг" хэмээх эртний натурфилософийн үзэл санааг уламжлан хөгжүүлжээ. Тэрээр одон орон, байгаль шинжлэлийн мэдлэг дээрээ үндэслэн, тэнгэр бол материаллаг зүйл, тэнгэрт од эрхэс, нар, сар хэмээх материаллаг зүйлс бий гэж үзжээ.

Тэрээр "байгальд өөрийн жам ёс бий. Байгаль нь өөрөө өөрийнхөө шалтгаан болдог. Байгалийг хэн ч бүтээгээгүй" хэмээн Дун Жун Шу-гийн теологи үзлийг шүүмжлээд "байгальд амьдралыг тэтгэгч эрч хүч бий. Ертөнц байнгын хөдөлгөөнд оршдог. Байгалийг тэнгэр (бурхан бүтээгээгүй. Өөрийн хуулиар л үүсч, оршин байдаг"<sup>1</sup> гэжээ.

**Хүний тухай үзэл.** Ван Чуны үзлээр, хүн бол байгалийн хөгжлийн дээд шат, байгаль дээр байдаг 360 төрлийн амьтдын нэг мөн. Хүний хувьд бусад амьтдаас ялгарах нэг гол онцлог нь мэргэн цэцэн ухаалаг байдал. Хүн ба байгаль салшгүй холбоотой. Хүн ба байгалийн харилцаа нь тэнгэрийн хүсэл зоригоос шалтгаалахгүй. Тэнгэрт мэдрэхүй, сэтгэхүй гэж байхгүй. Тэнгэр хүнийг шагнадаг, шийтгэдэг ч худал зүйл хэмээн Дун Жун Шу-г хурцаар шүүмжилсэн буй. Цааш нь, тэрээр үзэхдээ, хүн бол байгалийн нэг элемент. Хүний оюун санаа, сүнс нь мөнх бус, бие задрахад хамт устдаг. Хүн бол байгалийн инь, ян хүчний нэгдэл болох ци-гийн нягтралын үр дүнд бий болсон байгалийн амьтан гэжээ. Түүнчлэн хүний амьдрал дахь аз ба амжилт нь тэнгэрийн хүсэл зоригоос хамаарахгүй, гагцхүү тухайн цаг үе, нөхцөл байдалтай холбоотой байдаг. Жишээлбэл, амжилтад хүрэх зам янз бүр байдаг. Эрдэм мэдлэг, шударга ёс эсвэл хууран мэхлэлт гэх мэт, өөрөөр хэлбэл, тухайн хүний амьдрах чадвар, мэдлэг боловсрол, зан чанар, мөн удирдан чиглүүлж буй засаг төр зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг" гэжээ. Мөн хүний хувь заяа хэмээх асуудлын талаар Ван Чун өөрийн үзлийг тодорхойлсон байдаг. Хүний амьдрал сайн, муу байх, урт наслах эсэх, аз амжилт зэрэг нь байгалиас заяасан зүйл юм. Амьдрал ба үхэл нь тэнгэр бурхантай ямар ч холбоогүй, зөвхөн байгалиас хамаардаг хэмээн хүн байгалийн амьтан учир байгалийн хуулинд захирагдах нь зайлшгүй гэдгийг онцолж байв.

Хэрэв хүн байгалийн сайхан орчинд төрсөн бол амьдралын чадавх сайтай, эрүүл чийрэг байдаг. Ийм хүмүүсийн амьдралд аз, амжилт, бүтээл

<sup>1</sup> Ван Чун "Лунь Хэн" – Древнекитайская философия Эпоха Хань. М., 1990

их байдаг нь түүний хувь заяа хэмээн Ван Чун тайлбарлажээ. Од эрхэс нь хүний амьдралын эхлэлийг тавьдаг. Тухайн хүний төрсөн эрхэсийн зүгээс илгээх туяа, орчлон ертөнцийн илгээх туяатай нэгдэж хүнд нөлөөдөг ажээ. Хэрвээ тэрхүү туяа нь илч гэрэл сайтай байвал хүн ухаалаг, сайхан сэтгэлтэй төрдөг байна. Хэрвээ илч гэрэл муу байвал хүний амьдрал уруу дорой байдаг хэмээн үзжээ. Ийнхүү түүний үзлээр, хүний хувь заяа эхийн хэвлийгээс, төрөх үеийнх нь од эрхэсийн байрлалаас хамаардаг ажээ.

Ван Чун үхлийн тухай өөрийн зохиолд бичихдээ: "Байгалиас амьдрах эрч хүчийг буюу ци-г хүнд олгодог. Тэрхүү байгалийн эрч хүч суларч, алга болоход хүн үхдэг. Үхэл бол унтарч буй галтай адил. Үхлийн дараа хүний бие нь задарч тоос болон хувирч, сүнс нь тэнгэрт халин оддог. Тэгэхлээр амьдралын эрч хүч нь хүний амьдрал үхлийг тодорхойлогч гол зүйл юм. Үүнийг тэрээр устай зүйрлэн тайлбарласан буй. Ус зайрмагтсаар мөс болж хөлддөг нь амьдралын эрч хүч иймэрхүү замаар хүнийг бүтээдэг, мөн мөс нь хайлаад ус болно. Энэ нь хүн үхэхэд буцаад амьдралын эрч хүч болж хувирдаг гэсэн үг. Иймд нас барсан хүн хэлбэр дүрсээ алдан, бусдад муу зүйл хийж чадахгүй, бусдад хор хөнөөл учруулахгүй, сүнс мөнх бус хэмээн тэрээр өөрийн шашингүйн үзлийг илэрхийлжээ.

**Нийгэм улс төрийн үзэл.** Түүний үзлээр улс орны хувь заяа ч хүний хувь заяатай адил тухайн орны оршин буй газар нутаг, оддын байрлалаас шалтгаалдаг байна. Түүнчлэн улс орны хөгжил дэвшил, уруудал, доройтол нь нэг талаас байгаль, цаг ууртай их холбоотой. Нөгөө талаас, улс орны хувь заяа нь төрийн удирдлагатай шууд холбоотой ажээ.

Ван Чуны үзлээр, "Нийгмийн хөгжил нь цэцэглэлт, уналт, цэцэглэлт, уналт гэсэн уламжлан давтагдах үйл явц. Нийгмийн хөгжил нь дэвшин дээшлэх үйл явц. Эрт үеийн хүмүүс нь түүхий мах идэж, ангийн арьс нөмөрч, агуйд амьдарч байсан бол өнөө үед хүн үр тариагаар хооллож, торго даавуун хувцас өмсөж, гэр байшинд амьдрах болсон нь үүний нотолгоо"<sup>1</sup> гэжээ.

Мөн байгаль ба нийгэм нь харилцан их холбоотой. Эрт үеийн хүмүүс эрүүл чийрэг, урт насалдаг байсан нь байгальтай ойр байсан явдал мөн. Орчин үед хүмүүс эрүүл чийрэг бус, цагаасаа өмнө үхдэг болсон нь хүн байгалиас холдсон явдалтай шууд холбоотой гэжээ.

<sup>1</sup> Ван Чун. Лун Хан – Древнекитайская философия Эпоха Хань. М., 1990

Цааш нь тэрээр бичихдээ: "Эрт үеийн хүмүүсийг удирдахад хялбар байсан. Учир нь тэд ёс журмыг сайтар мэддэг, дагаж мөрддөг байв. Одоо цагийн хүмүүс нь ёс журмаа мэдэхгүй, сахихгүй болсон тул удирдахад хэцүү болсон" гэх зэргээр нийгмийн хөгжлийн түүхэн үе бүр өөр өөрийн онцлогтой болохыг авч үзжээ. Ван Чуны философи нь XIX-XX зууны Хятадын материалист философи, шашингүйн үзэлд нөлөөлсөн бөгөөд энэ талаар орчин үеийн Хятадын философич Фэн Ю Лань хэлэхдээ: "Ван Чун... хуучин үзэлтэй тэмцэж, шинжлэх ухааны скептицизмын гайхалтай санаагаараа ялгарч байсан хамгийн том сэтгэгч юм"<sup>1</sup> гэжээ.

Энэ бүхнээс үзвэл Ван Чун нь Хятадын философид шүүмжлэлт үзэл санаа, шинжлэх ухааны мэдлэгийн үүрэг ач хэлбогдолыг чухалчлан авч үзсэн анхны философич юм. Эцэст нь хэлэхэд, Хан улсын үеийн Хятадын философийн гол онцлог нь Күнзийн философи, материализм, натурализм, скептик үзэл, атейзм зэрэг олон үзэл баримтлал зэрэгцэн оршиж байсан явдал мөн.

#### Ашигласан ном зохиол.

- Великие мыслители Востока. М., 1994
- Древнекитайская философия Эпоха Хань. М., 1990
- История Китайской философии. М., 1989
- Китайская философия. Энциклопедический словарь. М., 1994
- М.Т. Степанянц. Восточная философия. М., 1997
- Фэн Ю Лань. Хятадын философийн товч түүх. УБ., 2003

<sup>1</sup> Фэн Ю Лань. Хятадын философийн товч түүх. УБ., 2003. 184 дэх тал.